



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/10/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор П.Энхжаргал

Утас: 9974-3112

Цахим хаяг: EnkhjargalP@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Албан шаардлага	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар

1. Аудитын санал дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.21 № 26
танай _____ -ны № _____ -т

АРХАНГАЙ АЙМГИЙН ГХБХБГ-ЫН
ДАРГА Ч.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,926,936.01	24,074,749.34
35	БАРАА МАТЕРИАЛ	32,926,936.01	24,074,749.34
35100	Түүхий эд материал	39,600.00	471,160.00
35110	Тусгай зориулалттай материал	39,600.00	471,160.00
35400	Хангамжийн материал	32,887,336.01	23,603,589.34
35410	Бичиг хэргийн материал	7,998,396.67	3,550,780.00
35420	Аж ахуйн материал	20,751,459.34	20,052,809.34
35430	Сэлбэг хэрэгсэл	2,380,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	1,757,480.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,001,010,723.24	966,577,919.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,001,010,723.24	966,577,919.63
39200	Биет хөрөнгө	988,754,056.46	954,467,919.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	847,317,023.86	847,317,023.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39,307,187.52	-58,960,781.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	192,500,000.00	192,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,437,500.06	-92,354,166.60
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	305,667,674.23	305,847,649.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-259,032,309.26	-255,374,121.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,094,208.20	49,172,821.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,047,852.99	-33,680,505.86
39300	Биет бус хөрөнгө	12,256,666.78	12,110,000.14
39301	Програм хангамж	1,530,000.00	1,530,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,273,333.22	-1,419,999.86
39303	Бусад биет бус хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=II+I	1,033,937,659.25	990,652,668.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,033,937,659.25	990,652,668.97
51	Засгийн газрын хувь оролцоо	1,033,937,659.25	990,652,668.97
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	408,307,915.32	408,307,915.31
51200	Хуримтлагдсан үр дүн	497,358,898.81	454,275,454.07
51210	Өмнөх үеийн үр дүн	497,560,444.35	497,560,444.35
51220	Тайлант үеийн үр дүн		-43,284,990.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	128,270,845.12	128,069,299.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,033,937,659.25	990,652,668.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	896,782,939.06	853,179,790.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,954,706.67	31,090,541.00
120	Нийтлэг татварын бус орлого	53,954,706.67	31,090,541.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,954,706.67	28,050,673.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,551,220.00	25,044,073.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,403,486.67	3,006,600.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	3,039,868.00

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	842,828,232.39	822,089,249.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	534,280,900.00	521,307,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	534,280,900.00	521,307,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	245,830,032.39	238,064,749.68
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,571,720.00	204,969,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,258,312.39	33,094,832.68
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,717,300.00	62,717,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,717,300.00	62,717,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	837,059,590.33	896,464,780.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	837,059,590.33	896,464,780.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,287,853.20	830,728,956.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	449,365,986.00	463,221,642.65
210101	Үндсэн цалин	297,609,351.89	318,323,187.52
210102	Нэмэгдэл	79,697,040.50	77,192,009.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,524,995.61	5,082,013.00
210105	Гэрээт ажлын хөлс	60,534,598.00	62,624,433.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,216,181.52	60,557,692.27
210201	Тэтгэврийн даатгал	40,306,516.52	44,325,153.55
210202	Тэтгэмжийн даатгал	4,011,600.00	4,202,582.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,209,300.00	3,271,346.26
210204	Ажилгүйдлийн даатгал	791,985.00	796,237.24
210205	Эрүүл мэндийн даатгал	8,896,780.00	7,962,372.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,431,374.74	60,834,157.08
210301	Гэрэл, цахилгаан	1,699,476.00	2,650,886.18
210302	Түлш, халаалт	54,164,064.00	53,529,904.00
210303	Цэвэр, бохир ус	567,834.74	4,653,366.90
2104	Хангамж, бараа материалын зардал	57,988,593.91	47,782,280.00
210401	Бичиг хэрэг	22,967,140.58	17,045,506.67
210402	Тээвэр, шатахуун	29,490,120.00	27,862,680.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	484,700.00	484,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,141,610.00	2,386,993.33
210408	Бараа материал акталсны зардал	2,905,023.33	2,400.00
2105	Нормативт зардал	4,103,070.00	2,625,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,103,070.00	2,625,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,868,800.00	64,592,804.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	160,000.00	0.00
210604	Урсгал засвар	2,708,800.00	64,592,804.00
2107	Томилолт, зочны зардал	18,870,600.00	22,327,000.00
210702	Дотоод албан томилолт	18,870,600.00	22,327,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	658,630.00	18,259,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	16,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	235,100.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	193,050.00	292,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,000.00	194,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,480.00	43,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,784,617.03	90,529,080.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,256,738.00	16,991,708.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,895,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,527,879.03	71,642,371.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,771,737.13	65,735,824.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,321,580.00	5,479,600.00

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,321,580.00	5,479,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,982,202.39	58,138,905.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,982,202.39	58,138,905.68
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,851,325.42	1,960,958.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,285,925.26	1,883,142.92
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,565,400.16	77,815.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,616,629.32	156,360.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,616,629.32	156,360.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	59,723,348.73	-43,284,990.28
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	59,723,348.73	-43,284,990.28

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,307,915.32	128,270,845.12	437,635,550.08	974,214,310.52
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,307,915.32	128,270,845.12	437,635,550.08	974,214,310.52
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	59,723,348.73	59,723,348.73
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,307,915.32	128,270,845.12	497,358,898.81	1,033,937,659.25
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	408,307,915.32	128,270,845.12	497,358,898.81	1,033,937,659.25
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	201,545.54	201,545.54
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,307,915.32	128,270,845.12	497,560,444.35	1,034,139,204.79
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-201,545.54	0.00	-201,545.54
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-43,284,990.28	-43,284,990.28
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	408,307,915.32	128,069,299.58	454,275,454.07	990,652,668.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	887,379,452.39	847,133,322.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,551,220.00	25,044,073.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,551,220.00	25,044,073.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,551,220.00	25,044,073.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,551,220.00	25,044,073.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	842,828,232.39	822,089,249.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	534,280,900.00	521,307,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	534,280,900.00	521,307,200.00

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	245,830,032.39	238,064,749.68
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,571,720.00	204,969,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	45,258,312.39	33,094,832.68
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,717,300.00	62,717,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,717,300.00	62,717,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	757,011,452.39	812,963,622.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	757,011,452.39	812,963,622.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,174,715.26	747,227,797.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	449,365,986.00	463,221,642.65
210101	Үндсэн цалин	297,609,351.89	318,323,187.52
210102	Нэмэгдэл	79,697,040.50	77,192,009.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,524,995.61	5,082,013.00
210105	Гэрээт ажлын хөлс	60,534,598.00	62,624,433.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,216,181.52	60,557,692.27
210201	Тэтгэврийн даатгал	40,306,516.52	44,325,153.55
210202	Тэтгэмжийн даатгал	4,011,600.00	4,202,582.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,209,300.00	3,271,346.26
210204	Ажилгүйдлийн даатгал	791,985.00	796,237.24
210205	Эрүүл мэндийн даатгал	8,896,780.00	7,962,372.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,431,374.74	60,834,157.08
210301	Гэрэл, цахилгаан	1,699,476.00	2,650,886.18
210302	Түлш, халаалт	54,164,064.00	53,529,904.00
210303	Цэвэр, бохир ус	567,834.74	4,653,366.90
2104	Хангамж, бараа материалын зардал	27,385,550.00	22,401,293.33
210401	Бичиг хэрэг	7,628,050.00	6,278,900.00
210402	Тээвэр, шатахуун	17,873,200.00	13,605,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	484,700.00	484,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,399,600.00	2,032,493.33
2105	Нормативт зардал	2,395,070.00	2,745,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,395,070.00	2,745,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,992,800.00	62,212,804.00
210604	Урсгал засвар	4,992,800.00	62,212,804.00
2107	Томилолт, зочны зардал	18,870,600.00	22,327,000.00
210702	Дотоод албан томилолт	18,870,600.00	22,327,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	658,630.00	18,259,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	16,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	235,100.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	193,050.00	292,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,000.00	194,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	36,480.00	43,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,858,523.00	34,668,058.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,858,523.00	32,773,058.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,895,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,836,737.13	65,735,824.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,386,580.00	5,479,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,386,580.00	5,479,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	73,982,202.39	58,138,905.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,982,202.39	58,138,905.68
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,851,325.42	1,960,958.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,285,925.26	1,883,142.92
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,565,400.16	77,815.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,616,629.32	156,360.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,616,629.32	156,360.30

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	130,368,000.00	34,169,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	130,368,000.00	34,169,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	130,368,000.00	34,169,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	130,368,000.00	34,169,700.00
223001	Бусад хөрөнгө	126,500,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,868,000.00	34,169,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-130,368,000.00	-34,169,700.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	584,024,500.00	581,984,996.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584,024,500.00	581,984,996.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	580,544,500.00	578,505,396.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,160,700.00	403,150,942.96
210101	Үндсэн цалин	298,380,400.00	316,557,598.46
210102	Нэмэгдэл	79,971,300.00	77,192,009.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,660,600.00	5,082,013.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,148,400.00	4,319,322.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,157,100.00	54,016,594.77
210201	Тэтгэврийн даатгал	38,110,600.00	37,784,056.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,011,700.00	4,202,582.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,209,300.00	3,271,346.26
210204	Ажилгүйдлийн даатгал	802,300.00	796,237.24
210205	Эрүүл мэндийн даатгал	8,023,200.00	7,962,372.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,717,300.00	60,834,157.08
210301	Гэрэл, цахилгаан	4,008,000.00	2,650,886.18
210302	Түлш, халаалт	54,758,400.00	53,529,904.00
210303	Цэвэр, бохир ус	3,950,900.00	4,653,366.90
2104	Хангамж, бараа материалын зардал	15,405,800.00	15,405,793.33
210401	Бичиг хэрэг	4,283,400.00	4,283,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,605,200.00	8,605,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	484,700.00	484,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,032,500.00	2,032,493.33
2105	Нормативт зардал	396,000.00	395,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	395,850.00
2107	Томилолт, зочны зардал	16,570,000.00	16,570,000.00
210702	Дотоод албан томилолт	16,570,000.00	16,570,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	764,400.00	759,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	235,100.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	292,300.00	292,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,000.00	194,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	43,000.00	43,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,373,200.00	27,372,758.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,373,200.00	27,372,758.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,480,000.00	3,479,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,480,000.00	3,479,600.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,480,000.00	3,479,600.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	584,024,500.00	582,141,357.08
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	521,307,200.00	521,307,200.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	521,307,200.00	521,307,200.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,717,300.00	60,834,157.08
320001	Орон нутгийн төсвөөс	62,717,300.00	60,834,157.08
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	38
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	35	35
620003	Үйлчлэх ажилтан	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	238,064,749.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	228,464,749.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,292,101.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,070,699.69
210101	Үндсэн цалин	1,765,589.06
210105	Гэрээт ажлын хөлс	58,305,110.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,541,097.50
210201	Тэтгэврийн даатгал	6,541,097.50
2104	Хангамж, бараа материалын зардал	6,995,500.00
210401	Бичиг хэрэг	1,995,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00
2105	Нормативт зардал	2,350,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,182,804.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00
210602	Тавилга	9,970,000.00
210604	Урсгал засвар	62,212,804.00
2107	Томилолт, зочны зардал	5,757,000.00
210702	Дотоод албан томилолт	5,757,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,600,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,895,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,895,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,172,648.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,172,648.49
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	33,094,832.68
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	77,815.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,600,000.00
222001	Тоног төхөөрөмж	9,600,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	238,064,749.68
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	238,064,749.68
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204,969,917.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,094,832.68

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үйл ажиллагааны орлоготой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 58 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь газар, барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуйн талаар гарсан хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, бүтээмж, чанарыг дээшлүүлэх, хөнгөн шуурхай, ил тод байдлыг хангах, орон нутагт мэргэжил, арга зүйн бодитой дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг ГЗБГЗЗГ-ын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуйн талаар гарсан хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, бүтээмж, чанарыг дээшлүүлэх, хөнгөн шуурхай, ил тод байдлыг хангах, орон нутагт мэргэжил, арга зүйн бодитой дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийлгэх хүсэлтийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Ц.Ганхүүд 2021 оны 06 сарын 18 -ны өдрийн 342 тоот албан бичгээр хүргүүлсэн хэдий ч хяналт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 584.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 4.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 43.2 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан бөгөөд материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Бараа материал	32.9	24.1	-8.8	-26.7
Үндсэн хөрөнгө	1,001.0	966.6	-34.4	-3.4
Нийт хөрөнгө	1,033.9	990.7	-43.2	-4.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,033.9	990.7	-43.2	-4.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,033.9	990.7	-43.2	-4.2

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- *Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 26.7 хувиар буурсан байна.*

Бараа материалын данс нь 32.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 50.2 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн

авсан 3.0 сая төгрөг нийт 53.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 62.0 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 24.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 3.4 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 1,001.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 34.2 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 3.0 сая, нийт 37.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 71.6 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 966.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Засгийн газрын хувь оролцоо 4.2 хувиар буурсан байна.*

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 990.7 сая төгрөг болж 43.2 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн 43.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	597.0	584.0	-13.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44.6	25.0	-19.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	245.8	238.1	-7.7
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9.4	6.0	-3.4
Үйл ажиллагааны орлого	896.8	853.1	-43.7
Цалин, шимтгэлийн зардал	506.6	523.8	17.2
Бусад бараа үйлчилгээний зардал	237.0	263.9	26.9
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.7	18.3	17.6
Бараа үйлчилгээний бусад зардал	92.8	90.5	-2.3
Үйл ажиллагааны зардал	837.1	896.5	59.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	59.7	-43.4	-103.1

Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 13.0 сая төгрөг буюу 2.2 хувиар буурсан нь Ковид-19 цар тахалтай холбоотой байна.Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 712.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 128.5 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 584.0 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 584.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 582.0 сая төгрөг зарцуулж 2.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жил нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын тамгын газраас 205.0 сая төгрөгийг санхүүжилт авсан байна. Үүнээс захиалагч инженерүүдийн цалинд 60.1 сая, НДШ-д 6.5 сая, сэлбэг хэрэгсэлд 7.0 сая, бичиг хэргийн зардалд 2.0 сая, тээвэр шатахуун 5.0 сая, сургалт, сурталчилгааны зардалд 3.4 сая, албан томилолтын зардалд 5.8 сая, нормын хувцас худалдан авахад 2.3 сая, урсгал засварын зардалд 55.2 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 2.0 сая, барилгын суурь үнэлгээ, оношлогооны зардалд 10.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил буюу замын техник хяналтын зардалд 16.0 сая, нийт 175.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна. Харин комьютер, принтер, лабораторийн тоног төхөөрөмж 19.6 сая, тавилга 10.0 сая, нийт 29.6 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авахад зарцуулсан байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын өөрийн орлогын хүрээнд бий болсон 33.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж улсын төсөвт шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар иргэд газрын кадастрын зураг, газрын гэрчилгээг www.egazag.gov.mn вэб порталаар дамжуулан үнэ төлбөргүй авдаг болсон нь үйлчилгээний орлого буурахад нөлөөлсөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 82.5 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 584.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 584.0 сая төгрөгийг зарцуулж, 99.7 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

- Албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд 1.8 сая төгрөг, албан томилолтын зардалд 22.3 сая төгрөг, бусад тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Суудлын автомашин ашиглалтын хувьд: ГХБХБГ нь нийт 3 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд 192.5 сая төгрөгийн анхны өртөгтэй, шатахууны зардалд 13.6 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 12.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Орон тооны 2 жолоочтой, жолооч нарын цалинд 15.6 сая төгрөгийг олгожээ.
- Бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 2.0 сая төгрөгийг хэмнэсэн нь нийт батлагдсан төсвийн 1.8 хувьтай тэнцүү байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн ГХБХБГ нь 2021 онд нийт 120.1 сая төгрөгийн 146 мэдээлэхээс 144 мэдээллийг хугацаанд нь ил тод мэдээлсэн хэдий ч 2 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан тул Шилэн дансны тухай хуулийн 6.3.6 “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл”, 6.4.8 “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг хэрэгжүүлэн мэдээллийг хугацаанд нь шилэн дансанд мэдээлж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Тус байгууллага нь батлагдсан төсвийн 1.8 хувийг хэмнэж 2.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба 8.2 хувийн буюу 10.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтын дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн мэдээллийг хугацаанд нь шилэн дансанд мэдээлж ажиллах гэсэн 2 зөвлөмж хүргүүлснийг 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтаар тулган шалгахад шилэн дансны мэдээллийг дахин хугацаа хоцроосон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Уг алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй 1 алдаа, зөрчлийн дүн 4.6 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 5.8 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Албан шаардлага

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсөвт зохицуулалт хийлгүйгээр бараа үйлчилгээний зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан 4.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн тухай авах зарим арга хэмжээ”-ний 1.4 “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад.....албан конторын тавилга, тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 2.1.1, 2019 оны 74-р тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журмын 5.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал							
1	ГХБХБГ	2	4.6	1	4.6	0	0
Дүн		2	4.6	1	4.6	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал							
1	ГХБХБГ	2	10.6	2	10.6	0	0
Дүн		2	10.6	2	10.6	0	0
Нийт дүн		3	15.2	3	15.2	0	0